

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг*

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>		
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>		1-2
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>		3-10
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/		3-10

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Ёс зүй, дэгийн байнгын хорооны  
12 дугаар сарын 03-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 13 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 61.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 30 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баасанжаргал;

Чөлөөтэй: Б.Жавхлан;

Тасалсан: Ж.Батсуурь.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Байнгын хороодын ажлын албаны Ёс зүй, дэгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Баярбаатар “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, А.Ариунзаяа, Д.Бум-Очир нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Баярбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат, Ч.Лодойсамбуу, Д.Рэгдэл, А.Ариунзаяа нар үг хэлэв.

**Б.Баярбаатар:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 0

Бүгд: 10

100 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 25 минут үргэлжилж, ирвэл зохих 13 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 76.9 хувийн ирцтэйгээр 15 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:  
ЁС ЗҮЙ, ДЭГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
15 цаг 30 минут.

### ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Баярбаатар:** Та бүхэндээ өдрийн мэндийг хүргэе. Ёс зүй, дэгийн байнгын хорооны 2024 оны 12 сарын 03-ны өдрийн хуралдаан ирц 61,5 хувь хүрсэн учраас хуралдааныг нээснийг мэдэгдье. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна, Баярмагнайн Баярбаатар ирсэн байна, Дуламын Бум-Очир гишүүн ирсэн байна, Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн байна, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн ирсэн байна, Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна, Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна, Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна. Хүрэлцэн ирээгүйгээс Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн гадаад томилолттой байгаа, Жамбын Батсуурь гишүүн ирээгүй байна, Болдын Жавхлан гишүүн бүлгийн хурал дээр мэдээлэл танилцуулж байгаа учраас чөлөө хүссэн. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн шалтгаан байхгүй, Доржзодовын Энхтуяа гишүүн ямар нэгэн шалтгаан хэлээгүй байна.

Өнөөдөр хэлэлцэх асуудлыг танилцуулна. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Тэгвэл хэлэлцэх асуудалдаа оръё. Байнгын хорооны гишүүдэд мэдээлэл өгнө. Бид нар өнгөрсөн хугацаанд бас хамтарсан Байнгын хорооноос дэг боловсруулж, Улсын Их Хуралд оруулсан боловч бол дэмжлэг аваагүй. Тэр үед би Их Хурлын чуулганы танхимын хуралдаанд хэлж байсан. Бид нарт Их Хурлаар, Их хуралд хуулиар олгогдсон 2 эрх байгаа. Нэг нь бол нэг удаагийн дэг боловсруулж оруулж ирж тэрүүгээр хэлэлцэж төсвөө батлах, хоёр дахь нь бол хуулийг хүчингүй болгох гэсэн ийм 2 эрх байгаа гэсэн. Тэгээд дэг дэмжигдээгүй учраас хууль хүчингүй болохоос өөр гарцгүй болсон учраас ингээд хууль хүчингүй болоод ингээд Төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт орж өнөөдөр Их Хурлын чуулганаар хэлэлцэж батлагдлаа.

Ингээд маргааш Засгийн газар хуралдаад төсвөө Их Хуралд өргөн мэдүүлэх юм шиг байна. Энэтэй холбогдуулаад өргөн мэдүүлсэн төсвийг бид ямар дэгээр хэлэлцэх вэ гэдэг асуудал ингээд дахиад ороод гараад ирж байгаа. Тэгэхээр 2 боломж байгаа бидэнд. Дахиад нөгөө 2 боломж байгаа гэдэг шиг. Нэг дэх нь бол Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хэлэлцэнэ. Энэ нь ямар вэ гэхээр одоо мөрдөгдөж байгаа Дэгийн хуульд өөрчлөлт оруулна. Ингэхээр бол бид нар хэлэлцүүлэг хоорондын хугацаа бол 5 хоног байдаг Дэгийн хуулиар. Тэгэхээр бид нар хэлэлцэх эсэх, анхны хэлэлцүүлгээр баталлаа гэж үзэхэд ажлын 10 хоног буюу энгийн горимоор 14 хоногийн дараа Дэгийн хуульд өөрчлөлт орно. Энэ бол нэг дэх боломж.

2 дахь нь бол, 2 дахь боломж нь бол яг нэг удаагийн дэг боловсруулна дахиад. Ажлын хэсэг гараад нэг удаагийн дэг боловсруулж, чуулганы хуралдаанд оруулж батлуулснаар хэлэлцэх асуудал юу төсвөө хэлэлцэх ийм боломж нь нээгдэж

байгаа юм гэж ойлгож байгаа. Тэгэхээр мэдээлэл өгөхөд бол ийм байна. Тэгээд энэ саяын миний хэлсэн 2 боломжтой холбоотойгоор, ажлын хэсэг байгуулахад ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй холбоотойгоор асуулт асууж, санал хэлнэ. Асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Харагдахгүй, Бум-Очир гишүүнээр, 3 гишүүн байна, Очирбат, Ариунзаяа гишүүн, Бум-Очир гишүүнээр тасаллаа. Очирбат гишүүн.

**Г.Очирбат:** Та бүгдэд өдрийн мэнд хүргэе. Тэгээд яах вэ бид нар бас нэг Ёс зүй, дэгийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо хамтраад ажлын хэсэг гаргасан. Ажлын хэсэг маань нэлээн сайн ажиллаад, хуулийн хүрээнд 16.3-ыг бариад хууль өргөн мэдүүлсэн. Тэгээд яалт ч үгүй улс төржилтийн юм гарсан шүү гэдгийг бас энэ дээр давхар хэлэх гэсэн юм. Ажлын хэсэг гэдэг бол ажлын хэсэг ажлаа боловсруулаад, Байнгын хорооддоо өгдөг. Манай Байнгын хорооны дарга болон Хууль зүйн байнгын дарга нар чуулган дээр ажлын хэсгийнхээ ажлыг бүтэн хамгаалж чадаагүй.

Дараа нь Жавхлан сайдтай би бүлэг дээр хэлсэн. Засгийн газар оруулж ирсэн юмаа хамгаалж чадахгүй бол мэргэжлийн Засгийн газар гэж байгаад хэрэггүй шүү гэж хэлсэн. Үүнтэй холбоотойгоор ажлын хэсэг одоо байгуулагдана гэх юм бол ажлын хэсгийн ахлагч болон ажлын хэсгийнхэн ажлаа хийгээд, Байнгын хороо руу өгнө. Байнгын хорооныхон Их Хурал дээр 2 талаас нь оруулж ирж байгаа хуулийн төслөө хамгаалах хэрэгтэй. Тэгэхгүй бол очоод ингээд л унагаачихдаг. Тэгээд л нэг улс төрждөг, АН-аас ажлын хэсгийг нь ахалчихсан болохоор унагааж байгаа юм уу, нэг бол яаж байгаа юм нэг тоглоом шоглоомын инээсэн маягтай нэг ийм байдалтайгаар ажил албаны юм явмааргүй байгаад байна.

3 гарц байгаа гэж харж байгаа. 1 дүгээрт бол бид нар энэ мэдээж бид нар түрүүн ингээд Төсвийн тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулаад, төсвийн төслийг дахин өргөн мэдүүлэх ийм хуулийг баталсан. Үүнтэй холбоотойгоор бол бид нар нэг бол нэг удаагийн энэ хуулиа гаргаад явъя гэдэг юм чинь уначихсан. Тэгэхээр Баярбаатар даргад бас хэлэх гээд байгаа нь бид нар энэ Дэгийн тухай хуулиа ер нь нэг ингээд өөрчлөөд авчихвал яасан юм бэ? Яагаад гэхээр бид нар 2026 он, 27 он, 28 оны төсөв батална. Энэтэй холбоотойгоор ер нь цаашдаа дахиад Ерөнхийлөгчийн хориг хэсэгчилсэн болон бүтнээрээ орж ирвэл хуулийн гарц гаргалгаа ямар байх юм бэ гэдгийг өнөөдөр бид нар шийдэх ийм түүхэн цаг хугацаа бол ирчхээд байна шүү дээ. Яг энэтэй холбоотойгоор бол урьд нь бол Ерөнхийлөгчийн хориг орж ирээд, хоригийг нь хүлээж авч байсан тохиолдол байхгүй.

Тэгээд үүнтэй холбоотойгоор бид нар энэ хуулийн ийм гацаанд орж эхэлсэн. Ингээд хууль бол яг өнөөдрийн байдлаар бол энэ Төсвийн тухай хууль дээр өөрчлөлт оруулаад баталчихлаа нэгд. Хоёрт гэх юм бол дараа нь энийг Их Хурлаар хэлэлцэх Дэгийн тухай хуулиа дахиад ийм байдал орж ирвэл яах вэ гэдэг утгаараа Дэгийн тухай хуульдаа бид нар өөрчлөлт оруулъя гэсэн саналтай байгаад байгаа юм нэгт.

Хоёрт гэх юм бол бас энэ ажлын хэсэгт орж, хэрвээ Дэгийн тухай хуулийг ерөнхийд нь ингээд өөрчилъе, дахиад ийм асуудал орж ирж байвал энэнээс гарц гаргалгааг нь хамтдаа шийдье гэвэл ажлын хэсэгт нь орж ажиллах сонирхолтой байна. Ингэж байж бид нар нөгөө Их Хурал дээрээ орж ирж байж Ардчилсан нам нь, Ардын нам нь бүгд нэг талдаа гараад, яг энэ улс эх оронд тулгамдаад байгаа төсөвтэй холбоотой асуудлууд жилийн жил ярина. Энэ байдлаасаа гарахын тулд

Дэгийн тухай хуулиа бүтнээр нь өөрчлөх энэ юм руугаа орвол зүгээр юм болов уу гэсэн саналтай байна.

**Б.Баярбаатар:** Санал хэллээ. Ариунзаяа гишүүн.

**А.Ариунзаяа:** Очирбат гишүүнтэй нэгэн адил нэг удаагийн хууль байх нь зохимжгүй юм гэдгийг хэлэх гэсэн юм. Миний хувьд бид Төсвийн тухай хуульд өөрчлөлт орж сая батлагдсан учраас бид Дэгийн тухай хуульд зохих өөрчлөлтийг оруулж, олон удаагийн ашиглах боломжтой дагаж орж ирэх ёстой юм байна гэсэн ийм ойлголтыг авч байна. Тэгэхээр энэ ажил маань өөрөө шуурхай хийгдэх ёстой учраас бүүр үндсээр нь том Дэгийн хуулиа хэлэлцэх нь өөрөө буруу. Ийм учраас яг энэ төсвийн дахин оруулж ирж байгаатай холбогдуулан Дэгийн хууль дээр ямар өөрчлөлт хийх вэ гэдэг дээрээ маш шуурхай ажиллаж, тэгээд Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга маань өөрөө ахлаад шуурхай энийгээ базаад явсан нь зүйтэй байх гэж үзэж байна.

2 дахь нь болохоор яг энэ дэг дээрээ ер нь байнгын энэ хурууны хээ уншихгүй байна, төхөөрөмж ажиллахгүй байна гэдэгтэй холбоотойгоор бидний төхөөрөмжүүд бол нүүр бас таних боломжтой юм байна лээ. Тэгэхээр үүнийг зохицуулахын тулд Дэгийн тухай хууль дээр нэг удаагийн танигдалтын аргаар гэдгийн ар талд нь хурууны хээгээр гэж тусгайлж зааж өгсөн хаалтад байгаа заалтыг авчих юм бол яг Улсын Их Хурлын Тамгын газрын Цахим газар бол нүүр танигдалтаар бас санал хураалтыг нь авах боломжтой гэдгийг илэрхийлсэн байгаа. Ингэснээрээ ямар нэгэн байдлаар хуруугаа хийж чадахгүй байгаа хүмүүс бол нүүр танигдалтаар нь боломжтой юм гэдэг ийм санал хэлэх гэсэн юм. Ажлын хэсгээ бол Баярбаатар дарга өөрөө ахлах боломжтой юу, үгүй юү гэдгийг хариулж өгнө үү.

**Б.Баярбаатар:** Бум-Очир гишүүн.

**Д.Бум-Очир:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Өмнө нь нэг удаагийн дэг Их Хурал дээр унасан. Тэгээд би бол унасан шалтгаан бол мэдээж олон янзын шалтгаан байгаа болов уу гэж бодож байна. Яг тийм АН-аас хүн ажлын хэсгийг ахалсан гэдэг бол шалтгаан биш болов уу гэж зүгээр найдаж байна. Тэгэхдээ мэдээж өөр ард нь юу ч байж магадгүй. Гол нь бол юу вэ гэхээр нэг удаагийнх байх хэрэг байна уу, үгүй юу гэдэг юмыг олон гишүүд ярьж байсан. Яг энэ удаагийнх дээр ч гэсэн ялгаагүй би Ариунзаяа гишүүн, Очирбат гишүүнтэй санал нэг байна. Нэгмөсөн Дэгийн тухай хуулиа засаад явбал яасан юм бэ? Тэгэхгүй бол ороод яг түрүүнийх шиг энэ шалтгаан нь гол шалтгаан болоод дараагийн удаа дахиад ийм кэйс гарвал яах юм бэ гэдэг ийм шалтгаанууд яриад, тэгээд дахиад унах ийм нөхцөл байдал үүсчих вий гэдэг дээр санаа зовниж байгаа.

Тийм учраас, энэ дээр гэхдээ нэг зүйлийг би болгоомжлол байгаа. Цаг хугацааны хувьд боломжтой юу? Бид нарт байгаа, түрүүн Баярбаатар дарга хэлж байна. Тэгэхээр цаг хугацааны хувьд боломжтой гэж үзвэл сайн харах хэрэгтэй байна цаглавраа. Тэгэхээр боломжтой гэж үзвэл Дэгийн тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах нь илүү зөв хувилбар болов уу гэсэн ийм саналтай байна. Тийм.

**Б.Баярбаатар:** Би товч бөгөөд тодорхой хариулъя. Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр би яг манай саяын асуулт асууж, санал хэлсэн 3 гишүүнтэйгээ адилхан байр суурьтай байсан юм. Яагаад гэвэл Төсвийн хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаа чинь нэг удаагийнх биш. Дараа жилийн төсвийн хууль дээр ч энэ

мөрдөгдөх юм байгаа юм. Тэгэхээр би Дэгийн хуульд ч гэсэн бас ингэж өөрчлөлт оруулъя гэдэг ийм зарчмын байр сууриа Даргын дэргэдэх зөвлөлөөр илэрхийлсэн юм.

Тэгээд 2 зүйл байгаа. 1 дүгээрт Засгийн газраас өөр субъект яаралтай горимоор хууль хэлэлцүүлэх боломж байхгүй. Буцаад Засгийн газар нь өөрөө дэгт нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл оруулах эрх байхгүй. Тэгэхээр Их Хурлын гишүүд нийлж байж эсхүл 1 Их Хурлын гишүүн Дэгийн хуульд өөрчлөлт оруулахаар санал оруулна, өргөн барина гэсэн үг.

Дараагийн нэг асуудал нь жишээлбэл Төсвийн хуулийг дагаж хуулиуд орж ирдэг дээр Дэгийн хууль ямар ч хуулийг дагаж орох боломжгүй, дангаараа орж хэлэлцүүлэгдэж байдаг ийм хуультай. Тэгэхээр одоо ингээд бид саналаа нэгтгээд үзвэл болохгүй биш болно. Ямар ч байсан 14 хоног бол хэлэлцэнэ зөвхөн Дэгийн хуульд өөрчлөлт оруулахын тулд. Өнөөдөр чинь төсөв бид нар ингээд өнөөдөр ингээд хэлэлцээд, хуулиа дэгээ боловсруулаад, маргааш өргөн барилаа гэж үзэхэд маргааш чинь хэдэн билээ 4. 4-өөс 18 хавьцаа батлагдана гэсэн үг, Дэгийн хууль батлагдаж гарч ирнэ гэсэн үг. Тэгэхээр энэ цаг хугацааны хувьд бол боломжгүй болчихоод байгаа юм. Болдог бол ингэмээр байна.

Ер нь бол миний байр суурь ч тэр, бусад Тамгын газрын удирдлагууд зүйлүүдтэйгээ нийлсэн. Ер нь эртхэн ажлын хэсэг байгуулъя гэсэн би бодолтой байгаа. Хаврын ээлжит чуулганаар Дэгийн хуульд өөрчлөлт оруулъя гэсэн саналтай байгаа. Саяын Ариунзаяа гишүүний хэлж байгаа санал, өнөөдрийн Их Хурлын даргын индэр дээрээс хэлдэг энэ Улсын Их Хурлын гишүүд хуруугаа дарчхаад гараад явчихдаг байдлыг яах юм бэ гэдэг асуудлуудыг, ингээд 30 минут болоод шууд ирцээс хасагдаад, тасалсан цаг руу шилждэг барьдаг иймэрхүү юм руу программа судалж оруулахгүй бол энэ чинь өөрөө Их Хурал өөрөө гаргаж байгаа шийдвэр нь санал хураалтаар унаад байгаа чинь болохгүй байгаа байхгүй юу.

Нөгөө гишүүн нь ирцдээ орчихоод гараад явчихдаг, дараа нь тэр хүн өөрийнх нь яг цэвэр байр суурь нь бол дэмжсэн байр суурьтай байж байдаг. Танхимд байгаагүйгээсээ болоод эсрэг саналдаа ороод, хамгийн гол асуудал нь энэ ард түмний төлөө, энэ иргэдийн нийтлэг эрх ашгийн төлөө гарч байгаа шийдвэр нь өөрөө унаж байдаг ийм асуудал байгаад байгаа байхгүй юу. Байгаад байгаа. Тэгэхээр миний оруулж байгаа санал бол ажлын хэсэг байгуулаад, ажлын хэсэг бол дотроо ямар дэгээр хэлэлцэх вэ барих вэ гэдэг саналуудаа өөрсдөө боловсруулаад явах нь зөв болов уу гэж би бодож байна. Надад бол оруулах санал бол эхлээд ямар ч байсан нэг ажлын хэсэг гаргаад явуулаадахъя.

Ажлын хэсэг өнөөдөр ажиллаад, маргааш өглөө 10 цагт манай Байнгын хороо товлочихсон байгаа. Ерөөсөө маш богино хугацаанд ажиллаад л, буцаагаад маргааш Байнгын хороондоо саналаа оруулж ирээд, Байнгын хороо тэрийг дэмжих юм бол чуулганы нэгдсэн хуралдааныг би маргааш үдээс хойш зарлуулах санал оруулах гээд байгаа юм. Зарлуулах санал оруулна. Тэр дараа, хаврын тийм. Дэг боловсруулах ажлын хэсэг. 1 удаагийн дэгээ боловсруулаад, маргааш өглөө 10 цагаас Ёс зүй, дэгийн байнгын хороо хуралдаж, хэлэлцээд Байнгын хороо дэмжсэн шийдвэр гаргавал үдээс хойш чуулгантай. Болохгүй гэж би ерөөсөө ойлгоогүй. 16.3-аар, тийм. Тэр чинь хамтарсан.

Одоо би дангаараа манай Ёс зүй, дэгийн байнгын хороо дангаараа ажлын хэсэг байгуулна, өөрсдөөсөө. Байгаа, байгаа, үүгээрээ л явна. Тийм. Энэ чинь зохицуулагдаагүй асуудал байхгүй юу. Дахиад төсөв өргөн барих гэж байна шүү дээ. Тийм. Санал хэлэх гишүүд. Очирбат, Лодойсамбуу, Ариунзаяа, Рэгдэл гишүүнээр тасаллаа. Очирбат, 1 нь хасагдчихлаа. Очирбат гишүүнээр.

**Г.Очирбат:** Би бол зүгээр зарчмынхаа байр суурь дээр л байгаад байгаа шүү. Энэ хамтарсан Байнгын хороодоос ажлын хэсэг гараад, тэгээд тэр нь уг нь яг хуулийн дагуу явсан. Тэгээд улс төржилт гэдэг юм уу нэг тийм үл ойлголцлоос болж энэ унагаасан. Тэгэхээр одоо ажлын хэсэг байгуулагдаж байвал би Лодойсамбуу гишүүнийг ажлын хэсгээ ахлаад, тэгээд Ёс зүйн байнгын хорооноосоо гишүүдээ нэмэлтээр аваад, тэгээд яг энэ асуудлыг бас ингээд нэг зөв байсан гэдгээ энэ нийгэмд болон Их Хурлын гишүүдэд нэг харуулаач гэж хэлэх гэсэн юм. Тэгээд санал.

**Б.Баярбаатар:** Лодойсамбуу гишүүн санал.

**Ч.Лодойсамбуу:** Тэр өнгөрсөн долоо хоногт тэр унадаг чинь манай гадагшаа явсан 2 гишүүн хүртэл тодорхой хэлье их харамсаж байгаагаа илэрхийлсэн зөндөө ажилласан учраас. Тэгээд тэр их олон шалтгаантай байсан л даа. Тэр өдөр жишээлбэл 40-өөд гишүүн гадаадад томилолттой явж байсан, Их Хурлын ирц тийм байсан. Нөгөө талдаа тэр Засгийн газар нь гэж хэлээд байгаа яах вэ Сангийн сайд, Даваасүрэн гишүүн 2 бол өөр бодолтой байсан Төсвийн байнгын хорооны дарга 2. Тэр 2 хоорондоо ярьж байгаад л үндсэндээ унагаасан. Тэгээд дараа нь хүчингүй болно гэдгээ тооцоогүй байсан юм байна лээ. Төсвийн байнгын хороон дээр ороод тэр дэг ер нь зөв байсан юм байна болоод эхэлсэн. Тэгэхээр тэр ойлголтын асуудал байсан.

3 дугаарт ажлын хэсгийг ахалж ороод асуултад хариулсан миний бас тэр асуудлаа гүйцэд ойлгуулаагүй ийм алдаа байгаа байх. Нөгөө талдаа би дахиад л нөгөө ярих гэж байгаа хариуцлагаа ярих гэж байгаа. Энэ гишүүд, бид нар чинь гишүүн болоод 5, 6 сар болж байна шүү дээ. Тэгээд ямар асуудал хэлэлцэж байгаа вэ, энэ асуудлыг дэмжихгүй бол яах вэ гэдгийг нь харилцан асууж хариулаад, хариулаад, тэрнийхээ дараа нь өрөө өрөөгөөр нь явж эсхүл утас руу нь мессеж бичиж, гуйж гувшиж, чирч гулдчиж оруулж ирж саналаа дэмжүүлдэг энэ байдал бол үнэхээр баймгүй. Ер нь энэ парламент тийм баймааргүй байгаа тухай би их олон удаа байр сууриа илэрхийлж байгаа. Ямар арван жилийн хүүхдүүд сургуульд орж байгаа биш дээ, иймэрхүү асуудал одоо хэлэлцэж байгаа шүү, энэ дээр нь дэмжвэл тэгнэ, дэмжихгүй бол тэгнэ гэж тайлбарлаж явах ямар ч шаардлагагүй. Ер нь цааш цаашдаа ийм нөгөө өрөө өрөөгөөр нь орж гуйдаг эсхүл утас руу нь ярьж гуйдаг ийм нэг ийм, Их Хурлын гишүүний үүрэгт ажлыг нь гуйж хийлгэдэг ийм зарчимгүй байдлыг бол алга болгох ёстой гэж бодож байгаа.

Одоо энэ нөгөө нэг Дэгийн хуульдаа ерөнхийд нь өөрчлөлт оруулах гээд түрүүн саналуудаа хэлж байна. Ер нь Дэгийн хуульдаа өөрчлөлт оруулах нь зөв гэдэгтэй өмнөх ажлын хэсгийг байгуулж байхдаа хүртэл бид нар ярьсан. Яагаад нэг удаагийн дэг гээд байгаа вэ гэхээр ерөөсөө л өмнөх ажлын хэсгээс авхуулаад бид нар энэ цаг хугацаанд шахагдаад байгаа ийм асуудал байж байгаа. Тэгэхээр яалт ч үгүй нэг удаагийн дэг гаргаад, энэ дэгээ зүгээр энэ Төсвийн хууль дээр байгаа биш ээ, Дэгийн хууль дээр байгаа төсвийг хэлэлцэх тэр дэгээрээ хэлэлцэх замыг нь нээх их л ажил байх шиг байгаа одоогийн байгуулагдах ажлын хэсэг дээр бол. Тэгээд би



энэ ажлын хэсгээ үргэлжлүүлээд ахалъя гэдэг дээр бол өөрөө тийм санал гаргаж байгаа. Яагаад гэхээр бас нэг юмны ард, ажлынхаа ард дуусгаад гарчихсан нь зөв байх. Тэр өнөөх гишүүд дэмжихгүйдээ ч биш, ойлгоогүй юм шиг байгаа юм. Зарим нь зориудаар ер нь, ер нь л ойлгоогүйгээс л болсон. Тэр бол тэр дараа дараагийн Байнгын хорооны хуралдаанаас гарсан. Тэгэхээр тийм саналтай байна.

**Б.Баярбаатар:** Лодойсамбуу гишүүнд баярлалаа. Рэгдэл гишүүн санал.

**Д.Рэгдэл:** Баярлалаа. Түрүүчийн Дэгийн хуульд өөрчлөлт оруулах асуудал хэлэлцэхэд миний бие бол байгаагүй тэр 32 гишүүний 1 байгаа юм. Тэгээд унасан гэж сонссон. Зүгээр өнөөдөр ер нь Их Хурлын даргын ярьж байгаа зүйлээс ойлгосон нь бол ерөнхийдөө Засгийн газрын гишүүд эсрэг санал өгөөд унагачихсан гэж ажлын хэсгийн ахлагч бас түүнийг мэдсэн юм байна, тэгсэн л юм байна лээ гэж ойлгож авсан. Зүгээр өнөөдөр бид нар Төсвийн тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулаад баталчихсан. Тэгээд тэр хуулийг чинь нөгөө 32.1.5 байна уу тийм түүн дээр чинь энэ жилдээ багтааж төсвөө бүх шатын төсөв батлагдах ёстой. Энэ жилдээ багтаж бүүр сум, дүүрэг хүртэл бүх төсөв батлагдах ёстой. Түүгээрээ бодоод үзэхээр яах аргагүй нэг удаагийн дэгээр явбал амжих магадлал бол нэлээн өндөр юм шиг харагдаад байгаа юм.

Зүгээр энэ Дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна гэдэг бол угаасаа л байж байх ёстой. Энийг бол би үнэхээр дэмжиж байгаа юм. Тэгэхээр зэрэг миний бодлоор бол энэ нэг удаагийн дэг оруулж ирэх ажлын хэсгийн ахлагч маань дараа нь Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсгээ дахиж ахлаад, үргэлжлэх маягаар ингээд явчихвал илүү үр дүнтэй, илүү оновчтой дэг... Дэгийн тухай хуулийн өөрчлөлт орох болов уу л гэж ингэж бодож байна. Баярлалаа.

**Б.Баярбаатар:** Санал хэлсэн гишүүддээ баярлалаа. Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсэг бол яах вэ дараагийн асуудал байж байгаа. Хэдүүлээ тэгээд юу яана ажлын хэсгээ байгуулна, бүх Байнгын хороодоос гишүүд орно. Нэгдсэн байдлаар Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдана. Тэгж байж тэр Дэгийн хуулийн өөрчлөлтийн асуудал тэр үед бол яригдана. Нэлээн судалгаатай, өнөөдөр өнгөрсөн хугацаанд гарсан дэгтэй холбоотой дутагдалтай асуудлуудыг бүгдийг нь тэмдэглээд явж байгаа. Тэгээд тэрийгээ нэгтгэж байгаад, манай Тамгын газар ч гэсэн энэ дээр тэмдэглэл хөтөлж байгаа юм байна лээ. Тэгээд нэгдсэн байдлаар Тамгын газар дээр дэд ажлын хэсэг байгуулагдана. Ингээд нэлээн том ажил болно. Тэгээд тэрийгээ дараа нь бид нар хаврын чуулганаар батлуулах болов уу гэж бодож байна. Ариунзаяа гишүүн, Ариунзаяа гишүүний микрофоныг.

**А.Ариунзаяа:** Энэ төсөвтэй холбоотой төсөв хэлэлцэх асуудал их чухал учраас хамтарсан ажлын хэсгээ Төсвийн байнгын хороотой байгуулж болох уу? Тэгвэл илүү үр дүнтэй юм шиг санагдсан. Сая бид нар Хууль зүйн байнгын хороотой хамтарсан ажлын хэсэг байгуулаад уг нь ажилласан шүү дээ. Тэгээд ер нь бол яг төсөв бол Төсвийн байнгын хороогоор илүү хэлэлцэгдэж, хариуцаж явж байгаа учраас Төсвийн байнгын хорооны өөрсдийнх нь яг энэ мэргэжил арга зүйн туслалцаа эсхүл саналууд нь их чухал юм байна лээ. Илүү хурдан гаргая гэх юм бол. Тэгээд энэ тал дээр нь Улсын Их Хурлын Тамгын газар болон Төсвийн байнгын хороотой хамтарсан ажлын хэсэг байгуулж болох уу гэсэн ийм саналтай байна.

**Б.Баярбаатар:** Яг энэ төсөв хэлэлцэж байгаа дээр үү?

**А.Ариунзаяа:** Одоо яг бидний нэг удаагийн дэгтэй.

**Б.Баярбаатар:** Энэ удаад бол ерөөсөө манай Байнгын хороо дангаараа хариуцлагаа хүлээгээд явна.

**А.Ариунзаяа:** Дангаараа л гэж байна уу тийм ээ?

**Б.Баярбаатар:** Тийм. Тийм зарчмын байр суурьтай байгаа. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. Ажлын хэсэг байгуулах тогтоолын төслийг би та бүхэнд танилцуулна. Байнгын хорооны даргын зүгээс би дараах нэрсийг ажлын хэсэгт оруулж ажиллуулах саналыг оруулна. Үүнтэй холбоотой та бүхэн санал байвал надад хэлж болно.

Ажлын хэсгийн ахлагч Чулуунбилэгийн Лодойсамбуу Улсын Их Хурлын гишүүн, гишүүдэд Г.Очирбат Улсын Их Хурлын гишүүн, Ариунзаяа Улсын Их Хурлын гишүүн, Д.Энхтуяа Улсын Их Хурлын гишүүн, хаана байна вэ, Д.Ганмаа Улсын Их Хурлын гишүүн, Б.Хэрлэн Улсын Их Хурлын гишүүн гэсэн 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулах саналыг оруулж байна. Заавал сондгой байх ёстой юу Тамгын газрынхан? Тэгвэл тэгээд Рэгдэл, Дүгэрийн Рэгдэл, ингээд 7 гишүүнтэй ажлын хэсгийн санал оруулж байна. Энэ ачаалалтай ажиллахгүй, та санаа зоволтгүй. Харин тийм ойлгож байгаа. Тэгвэл Бум-Очир гишүүн орчих юм уу? Тэгье. Тэгвэл Рэгдэл гишүүнийг чөлөөлөөд, Бум-Очир гишүүнийг оруулаад, ингээд 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулахаар санал оруулж байна.

Төсөлтэй холбоотой санал хэлэх гишүүд байна уу? Одоохон байж байгаарай. Энэ бүрэлдэхүүнтэй холбоотой санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй бол би тогтоолын төсөл уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр, Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Ёс зүй, дэгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг Улсын Их Хурлаар яаралтай хэлэлцэх дэгийн асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Ажлын хэсгийн ахлагч Ч.Лодойсамбуу Улсын Их Хурлын гишүүн, гишүүдэд Г.Очирбат Улсын Их Хурлын гишүүн, А.Ариунзаяа Улсын Их Хурлын гишүүн, Д.Энхтуяа Улсын Их Хурлын гишүүн, Д.Ганмаа Улсын Их Хурлын гишүүн, Б.Хэрлэн Улсын Их Хурлын гишүүн, 2, Д.Бум-Очир Улсын Их Хурлын гишүүн.

Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсгийн ахлагч Ч.Лодойсамбууд зөвшөөрсүгэй. Холбогдох саналыг нэн яаралтай боловсруулж, 2024 оны 12 дугаар сарын 04-ний дотор Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч Ч.Лодойсамбууд үүрэг болгосугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асууж, санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй бол Тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсэг, ажлын хэсгийн тогтоолын төсөл 90 хувиар, 10 гишүүн санал хураалтад

оролцож, 90 хувиар санал дэмжигдлээ. Рэгдэл гишүүний микрофоныг өгчих, Рэгдэл гишүүний микрофоныг өгье, та протоколд тэмдэглүүлье.

**Д.Рэгдэл:** Би сая саналаа өгөх гэсэн чинь нөгөө улаан юм нь гарч ирээд, тэгээд дахиад жаахан байж байгаад дараад амжсангүй. Тийм учраас би дэмжиж байгаа юм.

**Б.Баярбаатар:** Ингээд 10 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, тогтоол батлагдсан тул ажлын хэсэг хуралдаж яаралтай горимоор ажиллах үүргийг хүлээлээ.

15.55 цаг

Өнөөдрийн Байнгын хорооны хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хурлыг үүгээр өндөрлөө. Баярлалаа та бүхэнд.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Д.УЯНГА*

